

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 03.180

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага	MNS 6558 : 2015
Learning environment for preschool education organizations. General requirements.	

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 24 -ний өдрийн 55 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2016 оны 01 дүгээр сарын 18 -ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартын норматив шаардлагыг заавал мөрднө.

### 1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь сургуулийн өмнөх боловсролын байгууллага (цаашид цэцэрлэгт гэх) –ын сургалтын орчинд тавих шаардлагыг тогтооно.

### 2 Хамрах хүрээ

Энэхүү стандартыг сургуулийн өмнөх боловсралын үйлчилгээ зэрхэлж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, нийгмийн түнш, бапш, судлаач, сургуулийн өмнөх боловсролын сургалтын асуудал эрхэлсэн төрийн болон орон нутгийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд хэрэглэнэ.

### 3 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт) – ийг хэрэглэнэ.

- MNS 1-1, Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг: Стандарт боловсруулах арга зүй;
- MNS CAC RCP39:2011, Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал;
- MNS CAC/RCP 1:2003, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим: Олон улсын зөвлөмж;
- MNS 0900, Үндны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт;
- MNS 0004, Сургууль, цэцэрлэг, яслийн мебель. Ерөнхий техникийн шаардлага;
- MNS 3742, Цэцэрлэгийн мебель. Техникийн шаардлага. Зориулалтын хэмжээ;
- MNS 2749, Цэцэрлэгийн мебель. Хүүхдийн ор. Зориулалтын хэмжээ;
- MNS 6353, Цэцэрлэгийн хүүхдийн хөнжил цагаан хэрэглэл. Техникийн шаардлага;

## **MNS 6558 : 2015**

- MNS 6354, Цэцэрлэгийн хүүхдийн гудас. Техникийн шаардлага;
- MNS ISO 8124-4:2010, Тоглоомын аюулгүй байдал;
- MNS 370:2003, Монгол гарийн мод. Ерөнхий техникийн шаардлага;
- MNS 4990:2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, зүүл мэнд. Хөдөлмөрийн зүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага;
- MNS 4968, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага;
- MNS 4996:2000, Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавих ерөнхий шаардлага;
- MNS 4244:1994, Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;
- MNS 5150:2002, Цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага;
- MNS 5390:2004, Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;
- MNS 6440:2014, Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага;
- БНБД II-66-88 Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг тесел боловсруулах норм, дүрэм;
- БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцэн зураг тесел зохиох дүрэм;
- БНБД 40-05-98 Барилга доторх усан хангамж, ариутгах татуурга;
- БНБД 23-02-08 Байгалийн гэрэлтүүлэг ба зохиомол гэрэлтүүлэг.

### **4 Нэр томьёо, тодорхойлолт**

Энэхүү стандартад дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

#### **4.1**

##### **сургалтын орчин**

боловсролын стандарт, хеталберийг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг нахцал;

#### **4.2**

##### **сургуулийн өмнөх боловсрол**

бүх нийтийн анхдагч шат, хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд орох хүртэлх хугацаанд хөгжүүлэн төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, дадал, үнэт зүйлсийн тогтолцоо;

#### **4.3**

##### **хүүхдийн цэцэрлэг**

хоёр наснаас сургуульд элсэх хүртэл насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллага;

#### **4.4**

##### **ззэмшил газар**

хүүхдийг хөгжүүлж, төлөвшүүлэх зориулалтаар ашиглаж байгаа газар;

#### **4.5**

##### **сургалтын техник хэрэгсэл**

сургалтын үйл ажиллагаанд ашиглах албан ёсны болон бусад хэрэгсэл.

## 5 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчны нахцел

### 5.1 Гадна орчин

5.1.1 Цэцэрлэгийн эзэмшил газрыг хамгаалж тусгаарласан хашаатай байх биеөд хашааны өндөр 1,6 м-ээс багагүй байна. (Хашааны аюулгүй байдлын талаарх жишиг зургийг В.2-р зурагт үзүүлэв)

5.1.2 Эзэмшил газарт цахилгаан гэрэлтүүлэг, камертай байна.

5.1.3 Тоглоомын болон биеийн тамирын талбайд хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ сонирхолд нийцэн, хөдөлгөөнийг дэмжсэн тоглоомыг байрлуулах ба тоглоом нь ISO 8124 цуврал стандартын шаардлагыг хангасан байна. (жишиг зургийг В хавсралтад үзүүлэв)

ТАЙЛБАР 1: Цэцэрлэгийн онцлог, ўйл ажиллагаанаас хамаарч стандартын шаардлага хангасан тээврийн тоглоом, биеийн тамирын тоног төхөөрөмж ашиглаж болно.

5.1.4 Тоглоомын талбайд элсээр тоглох хэсэг байгуулан, элсийг гадны бохирдоос хамгаалан бүтээж, ашиглалтын шаардлага хангахгүй тохиолдолд тухай бүр солино. (жишиг зургийг В.9-р зурагт үзүүлэв)

5.1.5 Тээврийн хэрэгслийн зогсоолын талбайтай тохиолдолд стандартын шаардлага хангасан тэмдэг, тэмдэглэгээтэй байна.

5.1.6 Тоглоомын талбайд хүүхдийн тооноос хамааран сүүдрэвчтэй байна. (жишиг зургийг В.10-р зурагт үзүүлэв)

### 5.2 Барилга, байгууламж

5.2.1 Цэцэрлэгийн нэр (logo) эсхүл дугаарыг Монгол хал дээр бичсэн, стандартын шаардлага хангасан хаягтай байна.

5.2.2 Цэцэрлэгийн орох, гарах хаалганы шат довжоог хальтиргаанаас хамгаалсан байх, мөн хаалганы гадна орчинд цардсан талбайтай байна.

5.2.3 Цэцэрлэг нь орон сууцны барилгын нэгдүгээр давхарт байрладаг бол оршин суугчдын орциоос тусдаа хаалгатай байна.

5.2.4 Цэцэрлэгийн барилга нь галын болон аюулгүй байдлын дохиоллын системтэй байна.

5.2.5 Цэцэрлэгийн барилгад байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байхаас гадна агааржуулалтын системтэй байна.

5.2.6 Цэцэрлэгийн барилгын шатны хашлагын өндөр 1,2 м-ээс багагүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан шатны хашлагын өндөр 1,5 м-аас 1,8 м байна.

5.2.7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд зориулан барилгын хаалганы хэсэгт MNS 6055 стандартын шаардлагыг хангасан замтай байна.

**5.2.8** Стандартын шаардлага хангасан аянга зайлцуулагчтай байна.

**5.2.9** Цэцэрлэгийн анги, танхим, өрөөний байршлыг харуулсан план зургийг төв хаалгын ойролцоо байршуулсан байна.

**5.2.10** Цэцэрлэгийн техник, тоног төхөөрөмж, цахилгааны холбалтыг цахилгааны аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу гүйцэтгэсэн байна.

**5.2.11** Цэцэрлэгт ариутгал, халдвартгүйжилтийг улиралд нэг удаа хийж, бүртгэл хөтлөнө.

### **5.3 Бүлгийн өрөө**

**5.3.1** Бүлгийн өрөө нь хүүхэд тоглох, хичээллэх, унтаж, хооллох зэрэг олон талын үйл ажиллагаа явуулах боломжтой, осол аюулгүй байх нэхцлийг бүрдүүлсэн байна.

**5.3.2** Бүлэгт эмнэлгийн анхны тусламжийн иж бурдал байх бөгөөд шалнаас дээш 1,5 м-ээс 1,8 м өндөрт байрлуулсан байна.

**5.3.3** Бүлгийн өрөөний хана, шалны давсгэр нь хэт эрзэн бус, цайвар өнгөтэй, цэвэрлэгээ хийх боломжтой байна.

**5.3.4** Хүүхдэд ойлгомжтой зурагт байдлаар дүрсэлсэн аюулгүйн гарцын зургийг бүлэг бүрт хүүхдийн харааны түвшинд байрлуулсан байна.

**5.3.5** Бүлгийн өрөө нь агаарын солилцоо хангалттай явагдах нэхцелтэй, салхивч нь чөлөөтэй хаагдаж нээгддэг, ширеэ тоос орохоос хамгаалагдсан, ердийн болон механик агааржуулалтын төхөөрөмжээр хангагдсан байх ба (20-25)°C температурын дулаантай, харьцангуй чийгшил 45 % ( $\pm 7\%$ ) байна.

**5.3.6** Бүлгийн өрөөний хананд шалнаас 0,8 м -ээс 1,0 м -ийн өндөрт дулаан хэмжигч байрлуулж, температурыг хянана.

**ЗӨВЛӨМЖ:** Бүлгийн өрөөнд хүүхэд байхгүй үед агаарын солилцоог явуулан салхи оруулах бөгөөд хүүхдийг өрөөнд орж ирэхээс 30 минутын өмнө салхилуулалтыг эзгисноно. Өрөөний температурыг (2-4) °C-ээс хэтрүүлж бууруулахгүй байхад анхаарна. Мөн ариун цэврийн өрөөгөөр дамжуулан өрөөнд салхи оруулахгүй байвал эхисноно.

**5.3.7** Цэцэрлэгийн болон анги танхмын тавилга хэрэгслийг хадалгасангүй, тогтвортой байрлуулж, хүүхэд бэртэж, гэмтэхээс урьдчилан сэргийлсэн байна.

**5.3.8** Хүүхдийн бие эрхтэнд гэмтэл учруулах хурц үзүүр, ирмэгтэй болон шил, темреер хийсэн тавилга, тоног төхөөрөмж ашиглахгүй.

### **5.4 Ариун цэврийн өрөө**

**5.4.1** Цэцэрлэгийн хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөөг дотор байрлуулна.

**5.4.2** Ариун цэврийн өрөө нь агааржуулалтын системтэй, цонхны салхивч нь дээд талдаа байрласан байна.

**5.4.3** Ариун цэврийн өрөөний цахилгааны холболт нь далд байна.

**5.4.4** Ариун цэврийн өрөөний шал нь хальтирдагтүй материалыаар хийгдсэн, нэг түвшинд байна.

**5.4.5** Ариун цэврийн өрөөний суултуурууд хоорондоо тусгаарлагчтай, тусгаарлагчийн хажууд хүүхэд унахаас сэргийлсэн бариултай байна. (жишээ зургийг С хавсралтад үзүүлэв)

**5.4.6** Угааллын өрөө нь бохир, цэвэр хэрэгслийг хадгалах тусгай тавиур буюу шүүгээтэй, бохир зөвлөн эдлэлийг хүлзэн авах савтай байна.

**5.4.7** Цэвэрлэгээ, үйлчилгээнд ашиглах химийн бодис, ариун цэврийн хэрэгслийг хүүхдийн гар хүрэхгүй газар байрлуулна.

**5.4.8** Ариун цэврийн өрөөний угаагуур нь 1-р хүснэгтэд заасны дагуу байна.

#### Угаагуурт тавих шаардлага

1 -р хүснэгт

№	Хэмжээ	2-3 нас	4-5 нас	Тайлбар
1	Угаагуурын өндөр (иктүй)	50 см	60 см	Шалнаас дээш угаагуурын тавцан хүртэлх зайд
2	Угаагуур хоорондын зайд (багагүй)	50 см	50 см	Нэг угаагуурын Цоргоноос Негөө угаагуурын Цорго хүртэлх зайд
3	Угаагуурын өргөн (багагүй)	40 см	50 см	Угаагуурын өргөн
4	Толиниы өндөр (иктүй)	40 см	40 см	Угаагуур дээр байрлуулсан толиниы өргөн

**5.4.9** Хетөөч ашигладаг хүүхэд тус бүр тусдаа хетевчтэй байна.

**5.4.10** Ариун цэврийн өрөөний суултуур нь охид, хөвгүүдээр нь ялгасан таних тэмдэгтэй байна.

**5.4.11** Ариун цэврийн өрөөний суултуурын усны татуурга нь хүүхэд ашиглахад хялбар байна.

**5.4.12** Ариун цэврийн өрөөний суултуур нь 2-р хүснэгтэд заасны дагуу байна.  
/жишиг зургийг С хавсралтад үзүүлэв/

#### Суултуурт тавих шаардлага

2-р хүснэгт

№	Хэмжээ	2-3 нас	4-5 нас	Тайлбар
1	Суултуурын өндөр (иктүй)	20 см	27-28 см	Ердийн суултуурыг шалыг доош ухаж суулгаж болно.
2	Суултуурын урт (иктүй)	55 см	55 см	Хананаас суултуурын урд талын хэсэг хүртэлх зайд.

**MNS 6558 : 2015**

**5.4.13** 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгийн бүлгийн ариун цэврийн өрөөнд усанд орох шүршүүр байрлуулна.

**5.4.14** Шүршүүрийн хананд хүүхэд унахаас хамгаалсан баруултай байх бөгөөд хальтирахаас сэргийлсэн дэвсгэртэй байна.

**5.4.15** Хүүхдийн ариун цэврийн хэрэглэл нь тус бүрдээ таних тэмдэгтэй байна.

**5.5 Хөгжим, биесийн тамирын танхим**

**5.5.1** Хөгжим, биесийн тамирын танхимын шал нь дулаан хадгалах материалыаар хийгдсэн байна.

**5.5.2** Хөгжмийн танхимд хүүхдийн насыны онцлогт тохирсон хөгжмийн зэмсэг, техник хэрэгслийг ашиглана. (үлгэрчилсэн жагсаалтыг А.1 –р хүснэгтэд үзүүлэв)

**5.5.3** Хүүхдийн насыны онцлогт тохирсон биесийн тамирын хэрэгслийг ашиглана. (үлгэрчилсэн жагсаалтыг А.2 –р хүснэгтэд үзүүлэв)

**5.6 Гал тогоонд тавих шаардлага**

**5.6.1** Хүүхдийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг явуулахдаа MNS CAC RCP 39:2011 "Нийтээр нь үйлчилэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал", MNS 4946:2005 "Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага" стандартын үндсэн шаардлагыг хангасан байна.

**ЗЭВЛӨМЖ 1:** Чанарын баталгаажуулалтад хамрагдсан, шинжилгээний дүнэлтэй хүнсний бүтээгдэхүүнийг хүүхдийн хоол үйлдвэрлэлд хэрэглэж байвал зохионо.

**5.6.2** Хүүхдийн хоолны хэрэглэлийг бүлэгт байрлуулахгүйгээр гал тогооны хэсэгт зааврын дагуу угааж халдвартгүйжүүлэн, дахин бохирдохгүй нөхцөлд хадгална.

**5.6.3** Хот суурин газарт хоол хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын тээврийн хэрэгслээр тэзвэрлэнэ.

**5.6.4** Үндны ус зөөх, хадгалах сав нь таглаатай, угааж цэвэрлэхэд хялбар, хүнсний зориулалтын материалыаар хийгдсэн, хүүхдийн эрүүл мэндэд эрдэллгүй байна.

**5.6.5** Үндны болон ахуйн усанд жилд хоёроос доошгүй удаа эрүүл ахуйн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулсан байна.

**5.6.6** Цэцэрлэгт хэрэглэж байгаа аяга, таваг, хоолны сав хэрэгсал нь хүний биед хортой нөлөөгүй, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.

**6 Сургалтын хэрэглэгдэхүүнд тавих шаардлага**

**6.1 Нийтлэг шаардлага**

**6.1.1** Сургалтын хэрэглэгдэхүүн нь холбогдох стандартын шаардлага хангасан байна.

**6.1.2** Хөгжлийн бархшээлтэй хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай нь тэдний онцлогт тохирсон (товорилгосон гадаргуутай тэмтрэх боломжтой гэх мэт) байна.

### **6.2 Техник хэрэгсэл**

**6.2.1** Сургалтын техник хэрэгслийг бүлгийн өвөөнд хөдөлгөөнгүй байрлуулах болон зөвврийн техник хэрэгсэл ашиглах тохиолдолд тухайн хэрэгслийг аюулгүй ашиглах байдлыг хангасан байна.

**ЗӨВЛӨМЖ 1:** Техник хэрэгсэл ашиглах хугацаа нь 4 минутаас илүүгүй байвал зохих бөгөөд техник хэрэгслийг ашигласаны дараа анги танхимыг агааржуулж байна.

**ЗӨВЛӨМЖ 2:** Дэлгэц бүхий техник, хэрэгслэлийг ашиглах тохиолдолд, эхний эгнээний хүүхэд далгэнцнээс 1,8 м-ээс 2,0 м зйттай, сүүлийн эгнээний хүүхэд 4 м-ээс 6 м зйттай, хоёр хажуу талын хүүхдийн харах өнцөг 20-25 градусаас хэтрэхгүй байвал зохино.

**6.2.2** Хувилах, хэвлэх гэх мэт техник хэрэгслэлийг бүлгийн өвөөнд байрлуулахгүй.

### **6.3 Тоглоом, наадгай**

**6.3.1** Тоглоом, наадгай нь тухайн тоглоомын холбогдох стандарт болон ISO 8124 цуврал стандарт, MNS 0884 стандартын шаардлагыг хангасан байна.

**ЗӨВЛӨМЖ 1:** Сургуулийн өмнөх насын хүүхдийн тоглоомын хамгийн жижиг хэсгийн голч 30 мм-ээс багагүй, шаржигнадаг тоглоом доторх жижиг хэсгийн голч нь 55 мм-ээс багагүй байвал зохино. Бүлэгт сургах, хөдөлгөөнт, барьж байгуулах, жуужигчилж - сэдэвт, хөлжимт, холтгай зэрэг тоглоом наадгай байвал зохино. Гурав хүртэл насын хүүхдэд уяа, утас, шур, шагай зэргийг хэрэглүүлэхгүй.

### **6.4 Ном, бичгийн хэрэгслэл**

**6.4.1** Бүлэг бүрд хүүхдийн танин мэдэхүй, сэтгэхүй, хал яриаг хөгжүүлэх зорилгоор холбогдох стандартын шаардлага хангасан номын төвтэй байна.

**6.4.2** Өнгийн болон эсгий харандаа, баримлын шавар, зургийн цаас бусад хэрэглэгдэхүүн нь стандартын шаардлага хангасан байна.

## **7 Гэр цэцэрлэгт тавих шаардлага**

**7.1** Цэцэрлэг нь гэрт сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж болно.

**7.2** Сургалтын үйл ажиллагаанд гэр ашиглах тохиолдолд хүүхдийн осол аюулгүй байх нөхцлийг бүрдүүлж ажиллана.

**7.3** Гэр цэцэрлэгийн гадуур үер уснаас хамгаалсан суваг шуудуу татаж, гэрийг салхи, шуурганаас хамгаалсан байна.

**7.4** Гэрийн зуух нь гадуураа хамгаалалттай байна.

## 8 Галын аюулгүй байдал

8.1 Цэцэрлэгт MNS 5566 "Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гол унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм" стандартыг ханганд ажиллана.

8.2 Цэцэрлэгт нь болзошгүй, гэнэтийн аюулын үед авах арга хэмжээний бүдүүвч зургийг гаргаж, нийтэд харагдахаар газар байрлуулна.

8.3 Цэцэрлэг нь барилгын хүчин чадал, давхрын хязгаар, барилгын гол тэсвэршилгийн зэргийг холбогдох стандарт, нормын дагуу талевалсэн байна.

8.4 Гэр цэцэрлэгийн хашаан дотор галын сарааг шаардлагатай багаж хэрэгслийн хамт, зуны улиралд нөөц усан сантай хамгаалалтын хаалга, цоожтой байрлуулна.

8.5 Аврах хаалга, шатны хонгилд злэв зүйл хурааж хадгалахыг хориглож, зам гарцыг байнга чөлөөтэй байлгана.

8.6 Цэцэрлэгийн барилгад хялбар гал авалцан шатах, тэсэрч дэлбэрэх бодис материал хадгалахгүй.

8.7 Гал унтраагчийг цэнэглэж байнгын бэлэн байдалд байлгах бөгөөд гал унтраах хэрэгслийг ажиллуулах зааврыг бичиж тавьсан байна.

## 9 Хог хаягдал

9.1 Цэцэрлэгийн ердийн хог хаягдлыг хар өнгийн уут, эсвэл хар өнгийн ялгах тэмдэг бүхий хогийн саванд цуглувандаа.

9.2 Цэцэрлэгийн хашаан дотор худаг, хогийн сав, муу усны нүх байрлуулсан тохиолдолд таглаж битүүмжилсэн байна.

## 10 Бусад

10.1 Цэцэрлэг нь тусгай зохион байгуулалттай үйл ажиллагааны үед хүүхдүүдийг тээвэрлэхдээ Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан тээврийн хэрэгслээр MNS 5231:2003 стандартын шаардлагад нийцүүлэн үйлчилнэ.

**ЗӨВЛӨМЖ 1:** Хүүхэд тээвэрлэсэн тээврийн хэрэгсэл доторх хүүхдийг эмх журамттай зохион байгуулалттай авч явахыг тухайн үед томилогдсон багш нар хариуцна. Автобус бүр багштай явбал зохино.

ТӨГСӨВ.


**А ХАВСРАЛТ (Мэдээллийн)****Хөгжмийн замсэг, техник хэрэгслийн үлгэрчилсэн жагсаалт****A.1 дүгээр хүснэгт**

Д/д	Хэрэглагдахийн нэр	Тоо ширхэг
1	Төгөлдөр хуур	1 –ээс багагүй
2	Дараалтат хөгжим	1-2
3	Өвслөгч	1 –ээс багагүй
4	Чанга яригч	2 –оос багагүй
5	Цохиулур хөгжим	20 –оос багагүй
6	Систем хөгжим	1 –ээс багагүй
7	Чињавч	3 –аас доошгүй
8	Төлөвийзор	1 –ээс багагүй
9	Проектор	1 –ээс багагүй
10	Энгийн хөгжмийн замсэг /Төрөл бүр/	Нэг ангиин хүүхдийн тоогсоор
11	CD, хуурцаг	Тоо заахгүй.
12	Үндэсний хөгжмийн замсэг	
13	Топтоом, наадгай	
14	Хувцас, хэрэглэл	

**Биеийн тамирын хэрэгслийн үлгэрчилсан жагсаалт****A.2 дугаар хүснэгт**

Д/д	Нэр	Өндөр /мм/	Урт /мм/	Өргөн /мм/	Хүндийн жин /гр/
1	Хүүхдийн дэвсгэр	-	1000	-	-
2	Гүйлтийн зам /хүүхдийн/	-	-	-	-
3	Шатны мод	150	2400	100	-
4	Хүүхдийн хөдөлгөөнгүй дугуй	-	-	-	-
5	Хүүхдийн гантель	-	-	-	250, 500
6	Хөндийн тухай	-	-	-	500
7	Олс	-	2000	-	-
8	Зөвлөн зам	-	1800	-	-
9	Нүүр хаалга	500	-	500	-
10	Савлуур	2000	400	630	-
11	Көгли /ком/	-	-	-	-
12	Цагирган шидэгч /ком/	-	-	-	-
13	Цагираг	-	-	-	-
14	Матрас	2000	1380	-	-
15	Бай /үүдэг/	-	600	600	-
16	Бөмбөг /том/	-	-	Голч 200 - 250	-
17	Бөмбөг /дундах/	-	-	Голч 100 - 12	-
18	Бөмбөг /жюкиг/	-	-	Голч 60 - 80	-
19	Том цагираг	-	-	-	-
20	Хавттай цагираг	-	-	-	-
21	Гимнастикийн богино саваа Мод	-	750	-	-
22	Урт даас	-	-	-	-
23	Богино даас	-	-	-	-
24	Бандан	3000	240	300	-
25	Гимнастикийн модон хана	2700	800	-	-
26	Сагсан бөмбөгийн самбар	590	450	-	-


Эзэмшил талбай



ТАЙЛБАР:

- 1) Биөийн тамирын талбай  
2) Тоглоомын талбай  
3) Түршилтын талбай  
4.1, 4.2) Цацэрлэгийн барилга  
5) Сүүдэрэвч  
6.1) Зөвлөвчтэй талбай  
7) Мод бут бүхий ногсоон байгууламж  
8) Цацэрлэг рүү орох, гарах хаалга

В.1-р зураг - Эзэмшил газрын жишээ




ТАЙЛБАР 1: Дээрх аурагт үзүүлсэн нөхцлөөс урьдчилсан саргийг хашааг байгуулна.


В.2-р зураг - Хашааны аюулгүй байдлын жишээ

В ХАВСРАЛТ (Мэдээллийн) үргэлжлэл

Тоглоомын талбай




В.3-р зураг - Гулгуур (хажуу тал)



Тайлбар: 1) гулсах хоолой 2) элс бүхий талбай

В.4 -р зураг - Гулсах хоолой /дээрээс, метрзэр/

Тоглоомын талбай (үргэлжлэл)




Тайлбар: 1) Элс бүхий талбай

В.5 -р зураг - Савлуур урдаас харуулсан  
байдал /см-зэр/


В.6 -р зураг - Савлуур дээрээс харуулсан  
байдал /см-зэр/

В ХАВСРАЛТ (Мэдээллийн) үргэлжлэл

Тоглоомын талбай (үргэлжлэл)




В.7-р зураг – "Дүүжин даажин" тоглоом /метрээр/




В.8-р зураг – "Морьтой дүүжин даажин" тоглоом

В ХАВСРАЛТ (Мэдээллийн) үргэлжлэл

Тоглоомын талбай (үргэлжлэл)




В.9-р зураг – “Элсний хайрцаг” -ний загвар




В.10 -р зураг - Сүүдэрэвч (урдаас харуулсан  
байдал, см-ээр)      В.11 -р зураг - Сүүдэрэвч (дээрээс харуулсан  
байдал, см-ээр)

С ХАВСРАЛТ (Мэдэллийн)

Ариун цэврийн өрөө




С.1 -р зураг. Ариун цэврийн цаас, бариул  
бүхий тусгаарлагчийн загвар /мм-ээр/




С.2-р зураг. 2-оос 3 настай хүүхдэд  
зориулагдсан суултуур /мм-ээр/

**С ХАВСРАЛТ (Мэдээллийн) үргэлжлэл**




**C.3 -р зураг. 2-оос 3 настай хүүхдэд зориулсан угаагуур /мм-ээр/**



**C.4 -р зураг. 4-5 настай хүүхдэд зориулсан угаагуур /мм-ээр/**

D ХАВСРАЛТ (Мэдээллийн)



D.1-р зураг – Хүүхэд тээвэрлэх автобусны суудлын байрлал, хэмжээ



D.2-р зураг - "Хүүхдийн автобус"-ний таних тэмдэг, хэмжээ